ХЭНТИЙ АЙМГИЙН БАТШИРЭЭТ СУМЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Эгийн гол”

Батширээтчүүд бид Их эзэн Чингэс хааны нутаглаж байсан нутаг усанд нь амьдарч ууж байсан рашаан усаар нь ундаалан, түүний алтан ургийнхны галаа бадраж алдраа дуурсгасан Их Монголын хоймор нутаг Онон мөрний эхэнд суугаагаараа бахархан суудаг билээ.

Манай сум нь хуучин Сэцэн хан аймгийн Хөвчийн Дайчин Жонон Вангийн хошуу, Онон голын буриад хошуу, Биндэръяа уулын хошуу, Биндэр суманд багтаж байгаад 1952 оны 3 –р сард АИХ-ын тэгүүлэгчдийн 11-р зарлиг, Сн3-ийн 167-р тогтоолоор Биндэр сумын 5,6,7,8,9-р багуудыг нэгтгэн байгуулагдсан түүхтэй.

Батширээт сум 701,8 мянган га буюу 7018 мян. км^2 нутаг дэвсгэртэй. Хил хязгаарын хувьд хойд талаараа ОХУ-тай, зүүн талаараа Биндэр сум, баруун талаараа Өмнөдэлгэр сумдуудтай тус тус хиллэдэг.



Сумын нутаг дэвсгэрийн зураг

Сумын төв нь Хэнтий нурууны зүүн хэсгийн уулсын дунд Эгийн голын хөвөөнд далайн төвшнөөс 1100 гаруй метрийн өндөрт х.ө 48^{O} 41’ , з.у 110^{O} 10’ солбилцолд Өндөрхаан хотоос хойш 186 км, Улаанбаат ар хотоос зүүн тийш 413 км зайтай оршино.

Сумын нутаг дэвсгэрийн 80,3% буюу 563,6 мян.га-г ойн сан, 18,5% буюу 131,4 мянган га-г бэлчээрийн эдэлбэр нутаг, 0,02% буюу 8,5 мянган га-г суурин газрын эдэлбэр нутаг эзэлдэг.

Засаг захиргааны Онон, Барх, Хурх, Норовлин гэсэн 4 багтай. Нийт 766 өрх, 2313 хүн амтай. Хүн амын 70%-ийг буриад ястан, 30%-ийг халх ястан эзэлдэг.

Буриад үндэстнийхээ өв уламжлалыг сэргээх, хадгалах хамгаалах, өвлүүлэх зорилгоор 2015 оноос хойш ардын урлагийн “ Ёохор ” наадааныг сумынхаа эвент арга хэмжээ болгон олон улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж байна.

Хөдөлмөрийн насны 1693 иргэнтэй. Үүнээс ажиллагсад 847 , төрийн төсөвт байгууллагад 106 , хувийн хэвшилд 756 , хөдөлмөр эрхлээгүй 846 хүн байна.

2017 оны байдлаар 411 малчин өрхтэй ба нийт 65199 толгой малтай. Үүнээс тэмээ 5 , адуу 5719 , үхэр 18825 , хонь 25637 , ямаа 15013 толгой байна. Малын тоог сүүлийн 5 жилээр харуулбал:



1939 онд тус сумын эрчүүдээс 68 хүн халх голын дайнд оролцсоноос Ц.Гармаа, Базарын Дэлэгдорж, Ц.Ядамсүрэн нар Байлдааны гавъяаны улаан тугийн одонгоор шагнагдаж байжээ. 1938 онд Зуухын Баянголд Б.Лампран нарын санаачлагаар, Туяа, Шүхэр, Санж нарын санаачлагаар “ Ундрах” Эгийн голд Ц.Чойдог, Ц.Зундуйжамц нарын санаачлагаар “Эг” нэгдлүүд байгуулагдсан. 1940 онд эдгээр нэгдлүүд нэгдэж “Батжил- нэгдэл болсноор мал сүргээ өсгөн үржүүлэх үүлдэр угтсааг сайжруулах, гишүүдээ хөдөлмөрийн байраар хангах, газар тариалан туслах аж ахуй эрхлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байснаас гадна Эгийн голоос шуваг шуудуу татаж хүнсний ногоо эрдэнэ шиш тарьж шуудуугаа салаалан Борвооной өвгөний санаачлагаар тээрэм зоон цахилгаан эрчим хүч гарган банз зүсдэг байснаас гадна гахай, тахиа үржүүлэх, жимсний мод бут суулган давжаа алим, үхрийн нүд, мойл, чацаргана хураан авч байжээ. 1992 онд нэгдлийн зөвлөлийн хуралдаанаар “ Батжил” нэгдлийг татан буулгасан байна.

Мод бэлтгэлийн анхны аж ахуй Батширээтийн модны үйлдвэр 1964 онд Бархын шүтээн буюу Догшин дов хэмээх газар байгуулагдан анхны даргаар Д.Гүржав томилогдон ажилласнаас хойш жилдээ 60,0 мян.м3 гуалин бэлтгэдэг 350 гаруй ажилтантай үйлдвэр болон өргөжин ажиллаж байгаад 1990-ээд оны дундуур хувьчлагдсан байна.

Тус суманд 21 төлөөлөгч, 3 ажиллагсадтай ИТХурал, 22 ажиллагсадтай ЗДТГазар, 17 орон тоотой, 7 ортой Хүн эмнэлүй, 36 орон тоотой сурагч, 60 хүүхдийн тохилог дотуур байртай ЕБС, 17 орон тоотой 100 хүүхэдтэй Хүүхдийн цэцэрлэг, 325 суудалтай 6 орон тоотой Соёлын төв, 5 орон тоотой Хан Хэнтийн Тусгай Хамгаалалттай газрын Онон хэсэг зэрэг байгууллагууд нутгийн иргэддээ төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэж шамдан ажиллаж байгаагаас гадна СДОАнги, Батширээт тохижилт” ОНӨААТҮГ, Шуудан холбооны салбар, Эмийн эргэлтийн сан, Цаг уурын станц, ЗӨБЦТССалбар, ХААН, Хадгаламж банкны тооцооны төв, “ Петровис” ХК-ийн салбар ШТС, “ Сүү” ХК-ийн салбар, “Батширээтийн сүү”, Ононгийн сүү” зэрэг үйлдвэрүүд үйл ажиллагаагаа явуулж мод, сүү боловсруулах, худалдаа үйлчилгээ , аялал жуулчлалын чиглэлээр 30 аж ахуйн нэгж байгууллагууд ажиллаж байна.

Мөн Ардчилсан намын хороо, МАХН-ын хороо зэрэг улс төрийн намууд “ Ахмадын хороо”, “ Эмэгтэйчүүдийн зөвлөл”, “Байгаль хамгаалах “ Хөвчийн Жонон”, “Хөгжилд хүрэх зам”

Сумын жолооч нарын “Бат жолоо”, “Хавтгар ширээт” “ Ар хөвчийн унага” уяачдын холбоо, АА-нийгэмлэгийн “ Бат-ирээдүй ” бүлэг зэрэг төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Манай сум 2006 онд сансрын холбооны “ Всат” станц суурилуулж 2007 онд төвийн эрчим хүчний нэгдсэн ситемд холбогдон 2008 онд үүрэн холбооны “ Скайтель” “ Жи мойбайл” , 2012 онд Юнитель, Мобиком компаниуд салбараа нээж 2009 онд “ Батширээт FM-104 радиог байгуулсан нь сумын цаашдын хөгжил дэвшлийн үндэс суурь тавигдсан чухал үйл явдлууд болсон билээ. Мөн 2014 оноос шилэн кабелийн шугам тавигдан интернэтийн үйлчилгээ авах бүрэн боломжоор хангагдсан.

Манай сум түүх соёлын дурсгалт газар олонтой бөгөөд Монголын нууц товчоонд дурьдагдсан Тэргүүн Өндөр, Хорхонуг Жибур, Ихсийн газар, Хулдгар Хун, Бэдэр хошуу, Химурга горхи, Хорчихуй болдог, Ботохан бооржи зэрэг газрууд Биндэръяа уулын чулуун зэвсгийн бууц, Рашаан хад, Үзүүр цохионы сүг зураг, тамга тэмдэг , Хажуу нуурын буган хөшөө, Баянгол Эгийн Живхээстэйн хүн чулууд, Кидан улсын үеийн Өглөгчийн хэрэм, Өгөөмөр Ёл, Живхээстэй, Бархын дөрвөлжин булш зэргийг дурьдах байна.



Өглөгчийн хэрэм

Сумын төвөөс баруун урагш 40-өөд км, Биндэръяа хан уулын баруун хойд талд Дайчин гэх модтой уул байх ба энэ уулнаас Өглөгчийн гол эх аван урсдаг амны бэлд чулуу өрж барьсан хэрэм байдаг. Хэрмийн урд хэсэгт үүд байсныг гэрчлэх тасархайтай, дотор талдаа багавтар шороон далантай. Чулуун өрлөг зарим хэсгээрээ 2,5 м хүртэл өндөртэй бол зарим өндөр хэсэгтээ уулын зүүн хойд талд 5,1 м хүртэл өндөртэй байх ба өрлөгийн нийт урт нь 2,4 км юм.. Өглөгчийн хэрмийн дотор байх өндөр нэгэн хадыг Нутгийнхан Чингисийн морины уяа хэмээн домоглон ярилцдаг. Хэрмийн дотор ямар нэг барилгын ор мөр, туурь байхгүй боловч Киданы үеийн ваарны хагархай, сумны төмөр зэв зэрэг зүйлс түүвэр байдлаар олддог байна. МУИС-ийн НШУС Америкийн судлаачидтай хамтарсан хээрийн шинжилгээний анги малтлага судалгааны ажил хийж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар тус Хэрмийн дотор 10-аад булш байгааг тогтоогоод байгаа ажээ.

Рашаан хад орчмын дурсгалт газар



Нутгийнхан нүдэнд сайн хэмээн хаднаас дуслах усыг авч түрхэж хэрэглэдэг бөгөөд хадны ёроолоор түрэг, кидан, монгол, араб, төвд бичээс бий. Энэхүү дурсгалт газарт төвд бичиг-10 орчим, монгол бичиг-5, Хятад, Түрэг, Кидан бичээс- 10 орчим байдаг.

Ёлын байц орчмын дурсгал

Ёлын байцад нийт 25 дөрвөлжин булш байна. Дөрвөлжин булшнууд нь ихэвчлэн байцын баруун урд талаар төвлөрөн байрлах бөгөөд нимгэн том том хавтгай чулууг дөрвөлжилж хайрцаглан суулгаад голыг нь цөөн хавтгай чулуугаар даржээ.

Живхээстэйн амны дурсгал

Барх багийн нутагт, сумын төвөөс баруун зүгт 20 орчим км-т, Эгийн голын хойд биед Живхээстэйн амны дунд хэсэгт 2 хиргисүүр, хүний нүүрний дүрстэй хөшөө бүхий 5 байгууламж бий. Хөшөөт булш: Энд таван дөрвөлжин хэлбэрээр чулуу өрж хийгээд хойноос өмнө зүг цувуулан байрлуулсан чулуун хашлага тав байгаагийн 4 нь хүн чулуутай байна. Хүн чулуудын бараан өнгийн хүрмэн чулуугаар зөвхөн хүний нүүрийг дүрсэлж үйлдсэн байх аж. Хөшөө нь болхи хийцтэй, ямарваа нэгэн эд хэрэглэл, хувцас байхгүй учир чулуун хавтант хашлага, зүүн талдаа хүн чулууг байрлуулсанаар нь Түрэгийн үеийнх хэмээн таамаглав.

Улс орон, аймаг сумаа хөгжүүлэх үйлсэд манай сумын иргэд идэвхийлэн оролцож олон арван алдар гавъяатнууд төрөн гарсан юм. Монгол улсын Хөдөлмөрийн баатар М.Володъя, Монгол улсын төрийн соёрхолт яруу найрагч Нямбуугийн Нямдорж, Улсын сайн малчин Ш.Цэнд-Аюуш, С.Цэнд, Улсын хошой аварга малчин Р.Дорж, Улсын аварга саальчин Д.Тожил, Монгол улсын гавъяат геологич Д.Тогтох, Гавъяат жүжигчин З.Шагдар, Ш.Одончимэг, Гавъяат багш доктор профессор Н.Ням-Осор, Аж үйлдвэрийн гавъяат ажилтан Г.Базаргүр, БНЧех улсын гавъяат геологич доктор Д.Ренчинням,Улсын начин Ш.Шаравжамц, УИХ-ын гишүүн асан Ч.Ган-Өлзий, Н.Төвшинтөгс, АБЯ-ны орлогч сайд, аймгийн дарга асан Д.Аюуш, дэд сайд Б.Дэрдэв, С.Очирпүрэв, Аймгийн дарга асан С.Чимэдцэрэн нарын төр нийгмийн зүтгэлтнүүд, доктор Ж.Нанжид, С.Гомбо, Д.Чимиддорж, Ö.Áàòáàÿð, Б.Балжинням, А.Мөнх-Оргил, Клиникийн профессор А.Оюун нарын эрдэмтэн мэргэд, Монгол улсын алдарт уяач Г.Содном, чанарын улсын аварга Г.Сэрээтэр, Ой модны системийн аварга жолооч С.Дамдинжав, Эрүүлийг хамгаалахын аварга бага эмч Ж.Цэрэнчанаа, Ажил мэргэжлийн улсын уралдааны 3 удаагийн аварга Б.Дугдан, хошой аварга О.Чулуунбаатар, Л.Өрнөлт, Улсын залуу аварга малчин Б.Дэлгэрмаа, , Волейболын спортын нэрт дасгалжуулагч Г.Базарсад, Байт сурын олон улсын хэмжээний мастер Б.Долгормаа, гар бөмбөгийн олон улсын хэмжээний мастер Я.Энхмаа, Т. Оюундэлгэр, мото спортын ОУХ-мастер Б.Ган-Од, шатрын спортын анхны мастер Ц.Цэдэнжав, улсын мэргэн үндэсний сурын спортын мастер Г.Пүрэв, Д.Нямсүрэн, гар бөмбөгийн спортын мастер Ч.Төвшинтөр, Д.Жаргалсайхан, Т.Оюундэлгэр, Б.Ариунаа, А.Хэрлэнтооно, Л.Нэргүй, Д.Батболд, Ж.Отгонбаяр, Г.Ганболд, Ж.Одонтунгалаг, Р.Энхмаа, Нацагдоржийн шагналт зохиолч яруу найрагч Б.Нямаа, МЗЭ-ийн шагналт Л.Нямаа, С.Очиржав, Д.Дашшарав, Ш.Цэндгомбо, Б.Одгэрэл, Д.Гансүрэн, Б.Энхжаргал нарын уран үгийн дархцуул, Аймгийн аварга малчин Ц.Сандаг, А.Бэх-Очир, Я.Цэрэндорж, Ñ.Äàøñ¿ðýí , Аймгийн алдарт уяач Ц.Ичинхорлоо, А.Бэх-Очир, Х.Балжинням нар төрөн гарч 2002 оноос “ СУМЫН ХҮНДЭТ ИРГЭН” цол тэмдэг олгох тухай ИТХ-ын шийдвэр гарч Баганаар төвийн бүсийн ЦДСүлжээ ТӨХК –ийн Баганаар, Чойр салбарын ерөнхий инженер Д.Нямсүрэн, ИСИС-ийн ректор, Нутгийн зөвлөлийн дарга, доктор, профессор Н.Ням-Осор, “Альфа моторс” ХХК-ийн ерөнхий захирал Ч.ганхуяг, ГТХАН-ийн “Байгаль хамгаалал ба байгалийн нөөцийн тогтвортой менежмент” төслийн орон нутгийн зохицуулагч хатагтай Сандра Фолмейстр, Аймгийн Засаг дарга асан С.Чимэдцэрэн, ХААИС-ийн багш докторант Ш.Дэнсмаа , Түүхийн шинжлэх ухааны доктор, дипломатч Ц.Батбаяр, Шатрын их мастер Т.Батчимэг нар шагнагдаад байгаа нь Батширээтчүүд бидний бахархал болж байдаг юм.

Манай сум нь Хэнтийн нурууны салбар уулсын зүүн хойд талын хөвч тайгын бүс бүслүүр болон ойт хээрийн бүсэд далайн төвшнөөс дээш 1100-2300 метрийн өндөр өргөгдсөн нутагт оршдог билээ. Даёайн төвшнөөс дээш 2000м-с дээш өргөгдсөн Ноён, Хатан, Дуут Ян, Алаг Ян зэрэг өндөр уулстай,

Ноён хатан уул

Ононгийн халуун рашаан

Эрт дээр үед 108 худагтай байсан гэдэг бөгөөд одоогоор 10 орчим худагтай, 16-39 хэмийн халуунтай, үе мөчний болон мэдрэлийн гаралтай олон төрлийн өвчнийг анагаах зориулалтаар ашигладаг рашаан ус юм.

Онон, Эг, Барх, Хурх, Ашинга, хушинга зэрэг 61 гол, Цэгээн, Ёл, Булан, Биндэр, Живхийн нуур зэрэг 13 нуур цөөрөм Ононгийн халуун рашаан, тарц, Арангатай, Хужир нуга, Гүнталхаан, Сүүл толгой зэрэг халуун хүйтэн рашаантай.

Хурхын гол

Эгийн гол

Онон гол

Бархын гол

Ашигт малтмалын нөөцөөр арвин бөгөөд хайгуул судалгааны дүнд алт, хөнгөн цагаан, цагаан тугалга, төмрийн хүдрийн нөөц бүртгэгдсэн байдаг.

Сумын нийт нутгийн ойн сангийн ихэнх хувийг шинэсэн ой зонхилж хуш, нарс, улиас, хус, бургас, гацуур, жодоо зэрэг мод ургаж гол мөрний хөндийгөөр мойл, нэрс, хад, улаагана, аньс, нохойн хошуу, үхрийн нүд, гүзээлзгэнэ, долоогоно зэрэг жимс жимсгэнэ элбэг ургахаас гадна

тарваган шийр, алт мөнгөн гагнуур, бамбай, лидэр, сөд зэрэг эмийн ургамал, мангир, гогод, зэрлэг сонгино, цагаан төмс, төрөл бүрийн мөөг зэрэг хүнсний ургамал элбэг ургадаг ба

ой тайгад баавгай, буга хандгай, гахай нохой зээг, шилүүс, хүдэр, чоно, гөрөөс, булга, чандага, дорго, жирх, солонго, үе үнэг хярс зэрэг ан амьтан мэрэгчид амьдарч

ус голд нь тул, зэвэг, цурхай, гутаар зэрэг загас жараахай хур, сойр, хөтүү, ятуу, галуу, нугас, тоодог тогоруу зэрэг нүүдлийн шувууд болон суурин шувуудтай.



Уур амьсгалын хувьд өвөлдөө -15-49 хэм хүйтэрч зундаа +15+35 хэм дулаардаг. Байгаль цаг уурын эрс тэс уур амьсгалтай. Зундаа 200-300мм, өвөлдөө 100-200 мм хур тунадас ордог.

Манай сумын бүтээлч хөдөлмөрчид зүсмэл модон материал, дүнзэн байшин, буриад талх, мойлтой тос, цөцгий, словак бяслаг зэрэг брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, сумын ИТХ-ааpаа “ЭКО БАТШИРЭЭТ” хөтөлбөр, сумыг 2010-2020 онд хөгжүүлэх эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө, ойн хөтөлбөр, боловсон хүчний талаар бодлогыг батлуулан цаашдаа мал сүргийг чанаржуулах бодлого баримтлан загвар фермерийн аж ахуйг хөгжүүлэн, мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүний томоохон үйлдвэрлэл байгуулах,, байгалд халгүй үйлдвэрлэл үйлчилгээ, /модны үртэс ашиглаж шахмал түлш бэлтгэх, модны үртсэн хавтан үйлдвэрлэх, жимс ,ногоо

боловсруулах, савлах, цэвэр ус рашаан савлах, эсгий эсгий эдлэлийн үйлдвэр байгуулах, тул загас хамгаалах,өсгөх, нутагшуулах, ан харах байр, отог байгуулах, үр боргоцой бэлтгэх, боловсруулах цех байгуулах/ аялал жуулчлалыг хөгжүүлэн / Рашаан хадны орчмын түүх соёлын дурсгалт газрыг түшиглэн “ Тамга хүндэтгэлийн өргөөг барьж байгуулах/ иргэдийнхээ ахуй амьдралыг сайжруулах бодит зорилт тавин итгэл дүүрэн ажиллаж амьдарч байна.

“ Ононгийн сүү” ХХК-ын нэрийн бүтээгдэхүүн сүүн ааруул, мойлтой өрөм

Нутгийн брэнд бүтээгдэхүүн буриад талх, ёбочик, зөгийн бал

Мод модон материалын үйлдвэрлэл эрхлэн тусгай зөвшөөрөлтэй Батширээт” ХХК, Оргил буман од” ХХК, Хөвчийн нарс” ХХК, Үвгэн баавай” ХХК, Сайхан булаг хана” ХХК зэрэг ААНэгж, байгууллагууд үйл ажиллагаагаа тогтмол явуулж, банз, дүнз /токарын/ болон бусад материал үйлдвэрлэхээс гадна дүнзэн байшин барьж зах зээлд нийлүүлэх үйлчилгээ үзүүлж байна.